

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01- ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/	2022 оны 01 дүгээр сарын 01-ийн өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Компанийн нэр:Төрийн банк УБГД:000269587 Үнэт цаасны код-MN00SBM05643 Утасны дугаар: (+976) 11-312107
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүү
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Грант Торнтон аудит, 2014.01.29
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	755,096,250.0
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Тайланг бэлтгэсэн: мэргэжилтэн С.Болортуяа Хянасан: Д.Жадамбаа /Хөрөнгө зохицуулалтын газрын захирал/
1. Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хавсаргав. /Хавсралт №1/
Орлогын тайлан	
Өмчийн өөрчлөлтийн тайлан	
Мөнгөн гүйлгээний тайлан	
1.1. Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
	Жилийн санхүүгийн тайланг Грант Торнтон аудитын байгууллагаар баталгаажуулсан дүгнэлтийг хавсаргав. /Хавсралт №2/
1.2. Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/	
	Грант торнтон Аудит ХХК нь банкны 2022 оны санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу банкнаас хараат бусаар хөндлөнгийн аудитын үйлчилгээг хийж гүйцэтгэсэн гэдгээ "Хараат бус аудиторын дүгнэлт"-дээ тусгасан болно.
2. Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	

2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Аудитлагдсан санхүүгийн тайлангаар гол үзүүлэлтүүд 2022 онд нийт активын хэмжээ өмнөх онтой харьцуулахад 9.8 хувиар өсч 4,164.6 тэрбум төгрөгт, голлох орлого олдог активууд /зээл, үнэт цаас/ өмнөх онтой харьцуулахад 9.3 хувиар буурч 3,200.7 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт пассивын хэмжээ өмнөх онтой харьцуулахад 7.8 хувиар нэмэгдэж 3,668.4 тэрбум төгрөгт, өөрийн хөрөнгийн хэмжээ 27.7 хувиар нэмэгдэж 496.2 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна. Орлогын тайлангийн гол үзүүлэлтүүд болох хүүгийн орлого 2022 онд 397.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх онтой харьцуулахад 7.4 хувиар, цэвэр ашиг 97.3 тэрбум төгрөгт хүрч 112.7 хувиар тус тус өссөн байна. Хүүгийн зардал 175.8 тэрбум төгрөг буюу өмнөх онтой харьцуулахад 13.8 тэрбум төгрөгийн зардал хэмнэсэн байна. Банкны цэвэр ашиг 2022 онд 97.3 тэрбум төгрөг буюу өмнөх онтой харьцуулахад 51.5 тэрбум төгрөгөөр өсөхөд эх үүсвэрийн зардал 13.8 тэрбум төгрөгөөр, эрсдэлийн сангийн зардал 35.0 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь голлох нөлөөг үзүүлсэн байна. Банкны өөрийн хөрөнгийн өгөөж 2022 онд 22.97 хувь, активын өгөөж 2.57 хувь байна.																				
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	<table border="1"> <thead> <tr> <th data-bbox="702 873 1133 929">Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт</th> <th data-bbox="1133 873 1300 929">Байвал зохих</th> <th data-bbox="1300 873 1484 929">Биелэлт</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="702 929 1133 1019">Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа</td> <td data-bbox="1133 929 1300 1019">> 9%</td> <td data-bbox="1300 929 1484 1019">24.42%</td> </tr> <tr> <td data-bbox="702 1019 1133 1086">Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа</td> <td data-bbox="1133 1019 1300 1086">> 12%</td> <td data-bbox="1300 1019 1484 1086">24.42%</td> </tr> <tr> <td data-bbox="702 1086 1133 1153">Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт</td> <td data-bbox="1133 1086 1300 1153">> 25%</td> <td data-bbox="1300 1086 1484 1153">42.16%</td> </tr> <tr> <td data-bbox="702 1153 1133 1232">Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)</td> <td data-bbox="1133 1153 1300 1232">< (+ - 15%)</td> <td data-bbox="1300 1153 1484 1232">7.21%</td> </tr> <tr> <td data-bbox="702 1232 1133 1321">Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)</td> <td data-bbox="1133 1232 1300 1321">< (+ - 30%)</td> <td data-bbox="1300 1232 1484 1321">8.15%</td> </tr> </tbody> </table>	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Биелэлт	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	> 9%	24.42%	Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	> 12%	24.42%	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	> 25%	42.16%	Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	< (+ - 15%)	7.21%	Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)	< (+ - 30%)	8.15%		
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Биелэлт																				
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	> 9%	24.42%																				
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	> 12%	24.42%																				
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	> 25%	42.16%																				
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	< (+ - 15%)	7.21%																				
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)	< (+ - 30%)	8.15%																				
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Гадаад орчны төлөв оны эхэнд хийсэн төсөөллөөс тасралтгүй муудаж байгаа бөгөөд цаашид ч энэ байдал үргэлжлэх төлөвийг олон улсын байгууллагууд илэрхийлж байна. Тухайлбал, 2022 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл энэ оны эхэнд 4.4 хувь байсан бол шинэчлэгдэх бүрт муудсаар 2022 оны 8 дугаар сард хийсэн төсөөлөөр 3.0 хувь болж буураад байна. Үүнд АНУ, БНХАУ, Евро бүс, ОХУ зэрэг глобал эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч томоохон улсуудын эдийн засгийн өсөлт буурсан нь том нөлөөтэй байна. Банкны системийн нийт актив 2022 оны IV улиралд 44.2 их наяд төгрөгт хүрлээ. Улирлын онцлогоос хамааран нийт системийн хэмжээнд актив өсөхөд Төрийн банкны актив өссөн үзүүлэлттэй байна. Манай банк нийт 2 сая харилцагчид 114 төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэн ажиллаж байна. 2022 онд бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж харилцагчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн дундаж давхаргыг дэмжих санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, банкны бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх зорилгоор хадгаламж, зээл болон картын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэн ажиллаж байна. Бид дунд хугацаандаа хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг дээдлэн, нийгмийн дундаж давхаргыг дэмжих, жижиг дунд бизнесийг хөгжүүлэх, өрхийг орон сууцжуулах, барилгын салбарын ажлын байрыг нэмэгдүүлэх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн, байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, олон улсын жишигт нийцсэн санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлэгч Үндэсний тэргүүлэгч банк байх зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.																				

2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээний талаарх тайланг хавсаргав. /Хавсралт №3/
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Тайлант хугацаанд авсан зээл байхгүй.
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээллийг хавсаргав. /Хавсралт №4/	
4.	Цалин урамшууллын мэдээлэл	
	Тайлант хугацааны турш Банкны захирлууд болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд олгосон цалин урамшууллын дүн-1,436,958,000.0 /Нэг тэрбум дөрвөн зуун гучин зургаан сая есөн зуун тавин найман мянга/ төгрөг байна.	
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
	Компанийн засаглалтай холбоотой мэдээллийг хавсаргав. /Хавсралт №5/	
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл	
	Төрийн банкны Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон зах зээлийн эрсдэлийг удирдах зөвлөмжийн дагуу гадаад валютын позицгийг удирдан ажилладаг. Гадаад валютын ханшийн эрсдэлээс сэргийлэхийн тулд Монголбанк болон бусад санхүүгийн байгууллагатай своп хэлцэл хийн хамтарч ажилладаг. Мөн харилцагч байгууллага, иргэдийг гадаад валютын ханшийн эрсдэлээс сэргийлэх своп, форвард хэлцлийг санал болгон хэлцэл хийдэг. Төрийн банк нь зах зээлийн эрсдэлийг нэгдсэн эрсдэл үнэлэх аргачлал, стресс тестийн шинжилгээ зэргээр үнэлж холбогдох хороодод танилцуулж ажилладаг. Холбогдох хороодоос эрсдэл, ашгийн оновчтой хэмжээнд барих зорилгын хүрээнд тухай бүр шийдвэр гарган эрсдэлийг удирдаж ажиллаж байна. Төрийн банк нь хөрвөх чадварын эрсдэлийг удирдах дотоод журамтай ба уг журамд хөрвөх чадварын хүндрэлийн үед хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тодорхой тусгагдсан байдаг. Хэрэв шаардлагатай нөхцөл байдал үүсвэр банк тус төлөвлөгөөний дагуу ажиллах зохицуулалттай байна.	
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/	
	Нийт 755,096,250.0ш хувьцаатай, 7,371 хувьцаа эзэмшигчтэй байна. Сангийн яам-49,26% Хадгаламжийн даатгалын корпораци-45,03% Олон нийт 5,71%	
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжисж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл	
	Олон нийтээс татан төвлөрүүлсэн 25.4 тэрбум төгрөгийг Тогтвортой хөгжилд чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээнд 50 хувийг болон Нийгмийн дундаж давхаргад чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээнд 50 хувийг тус тус зарцуулахаар төлөвлөснөөс тайлан хугацаанд буюу 2022 оны 12 дугаар сарын 31 –ний өдрийн байдлаар Тогтвортой хөгжилд чиглэсэн бүтээгдэхүүнд 12.7 тэрбум төгрөгийг хуваарилснаас 3.1 тэрбум төгрөг, Дундаж давхаргад чиглэсэн бүтээгдэхүүн 12.7 тэрбум төгрөгийг хуваарилснаас 12.0 тэрбум төгрөг зарцуулсан үзүүлэлттэй байна. Төр засгаас явуулж буй бодлого шийдвэрүүдэд нийцүүлэн Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулах, орон нутгийн иргэд, жижиг дунд аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх чиглэлийг баримталж орон нутагт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 60 хувь болох 15.2 тэрбум төгрөгийг, Улаанбаатарт 40 хувь болох 10.2 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр орон нутагт 8.4 тэрбум төгрөг, Улаанбаатарт 6.7 тэрбум төгрөгийг зарцуулаад байна.	

9.	Ногдол ашигийн мэдээлэл
Тайлант хугацаанд ногдол ашиг олгоогүй.	
10.	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл
<p>ХҮРЭЭЛЭН ТӨСӨЛ - Байгаль эхээ хамгаалах, хойч үеэ байгальд хайртай иргэн болгох зорилгоор Хүрээлэн төсөлтэй хамтарсан “Эко карт” зах зээлд гаргаж борлуулсан карт бүрээсээ 1000 төгрөгийг “Хүрээлэн” төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулж, “Амьд ертөнцийн цуврал” нэвтрүүлгийн хорин дугаарыг үзэгчдийн хүртээл болголоо.</p> <p>2. ОЮУНЛАГ ЗАЛУУСАА ДЭМЖЬЕ” АЯН - Төрийн банкнаас Монгол хүний оюуны чадамжийг Дэлхийд гайхуулж буй “Оюунлаг залуусаа дэмжих” аяны хүрээнд Монголын шатрын холбоо, Шатрын их мастер, Монгол Улсын Гавьяат тамирчин Ц.Батчулуун, Дэлхийн 3 удаагийн аварга, өсвөрийн шатарчин Д.Мөнхзултай хамтран ажиллаж байна.</p> <p>3. БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ ҮНДЭСНИЙ ӨДӨРТ ТӨРИЙН БАНК НЭГДЛЭЭ - “Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газраас хэрэгжүүлж буй “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-т Төрийн банкны хамт олон нэгдэж Буйлсны суулгацыг Сонгинохайрхан дүүргийн 24-р хороо “Бумбатын булаг”-т тариала. Мөн “Банкны ажилтны өдөр”-ийг тохиолдуулан Монголын банкны холбоо, Холбооны гишүүн арилжааны банкууд, “Төгс хандлагаа өөрчилъе” ТББ-тай хамтран Богд ууланд 700 ширхэг шинэс модны суулгац тарьж төгөл байгуулсан.</p> <p>4. ЗӨВЛӨМЖ, МЭДЭЭЛЭЛ - Нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран ажиллах 02а/270 тоот гэрээний дагуу харилцагчдаа цаг агаарын болзошгүй тохиолдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор Гялсбанк аппликейшны мэдэгдэл хэсгээр нийт 52 удаагийн мэдээлэл хүргүүлж ажилласан.</p> <p>5. “ГЯЛС ЦЭВЭРЛЭГЭЭ” - Нийгмийн хариуцлагын хүрээнд “Байгальд ээлтэй Гялс цэвэрлэгээ-2022”-г аяныг өрнүүлж 6,000 орчим га газрыг цэвэрлэлээ. Энэ хүрээнд Улаанбаатар хотын Туул гол, Сэлбийн голын сав газар, Орон нутагт тухайн аймаг, сумын гол горхи, ундны усны сав газрыг цэвэрлэж 735 тонн буюу нийт 400 орчим автомашин хог хаягдлыг цэвэрлэлээ.</p>	
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
<p>Овог, нэр: Ө.ГАНТӨР</p> <p>Албан тушаал: ГҮЙЦӨЛГӨХ ЗАХИРАЛ</p> <p>Гарын үсэг:</p> <p>(Тамга/тэмдэг)</p> 	
Мэдээлэл хянаж хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
<p>Овог, нэр: Д.ЖАДАМБАА</p> <p>Албан тушаал: ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ</p> <p>Гарын үсэг:</p> 	